

ҮНДЭСНИЙ БИЧИГ III ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2021 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Нэг. Удирдлага, зохион байгуулалт

Үндэсний өв, бичиг, соёлыг сурталчлан, түгээн дэлгэрүүлж, үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн албан хэргийг 2025 оноос эхлэн хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан бэлтгэл ажлын хангах хүрээнд Дундговь аймгийн Засаг даргын баталсан “Үндэсний бичиг III” хөтөлбөр /2020-2021/-ийг хэрэгжүүлэх зорилгоор үндэсний бичгийг газрын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлын хэсгийг 2021 оны А/11 дүгээр тушаалаар томилон үүрэг, чиглэл өгч, 2021 онд хийх ажлын 21 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан биелэлтийг ханган ажиллаж байна.

Тус газрыг хариуцсан ажиллах сургагч багш Э.Баттогтохтой нийт бүрэлдэхүүн гэрээ байгуулж, Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 1/419 тоот “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай”, 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Үндэсний бичгийн олон талт арга хэмжээ зохион байгуулах ажлын удирдамж, “Үндэсний бичигтэн” төрийн албан хаагч шалгаруулах болзол /анхан, дунд шат/, Төрийн албан хаагчдад зориулсан монгол хэл бичгийн модуль сургалтын хөтөлбөрийг тус тус танилцуулсан.

Хоёр. Сургалт зохион байгуулсан талаар




Алба хаагчдаас Монгол бичгийн гарааны шалгалтыг алба хаагчдаас бичих болон унших чадвараар авч анхан, дунд шатанд хуваарилан танхимийн 2 цагийн сургалтад давхардсан тоогоор 73 алба хаагчдыг хамруулсан.

“Монгол бичгээ бие даан сурах анхны хичээлүүд” номыг 40 ширхэгийг захиалан авч, нийт бүрэлдэхүүн “Дундговь аймгийн Төрийн албан хаагч” файсбүүк групп-д нэгдэн, цахим 1-11 дүгээр хичээлийг тус тус судалсан.

Гурав. Бусад

“Дундговь аймгийн Онцгой байдлын газар” файсбүүк групп-ээр дамжуулан үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх, үйл ажиллагааны талаарх мэдээллийг байршуулан олон нийтэд сурталчлан ажилласан.

ТАЙЛАН БИЧСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ
СУРГАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ДЭД ХУРАНДАА Б.МӨНХЖАРГАЛ



[illegible][illegible]